Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол,шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283,956,4 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 98,331,9 | 359,421,4 | 261,089,2 |
| Авлага | 1,282,9 | 1,500,0 | 217,1 |
| Бараа материал | 354,555,3 | 464.461.2 | 109.868.3 |
| Үндсэн хөрөнгө | 3,775,982,9 | 3,877,384,5 | 101,301,6 |
| Хуримтлагдсан элэгдэл | -895,677,5 | -1,084,295,5 | -188,618,0 |
| **Нийт хөрөнгө** | **3.334.475.7** | **3.618.432.1** | 283.956.4 |
| Өр төлбөр | 6.932.1 | - | -6.932.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **3.327.543.5** | **3.618.432.1** | 290.888.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3.334.475.7** | **3.618.432.1** | 283.956.4 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 98,331.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 359,421.4 мянган төгрөгийн өмнөх оноос 261,089.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Сургуулийн захирлын 2023.12.25-ны өдрийн А/58 дугаар тушаалаар нийт 13,688.2 мянган төгрөгийн бараа материал акталж хөрөнгөнд тусгай зориулалтын материалын дансанд 103,513,7 мянган төгрөгийн бараа материал орлого авсантай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл 109,868.3 мянган төгрөгөөр өмнөх оноос бараа материал өссөн байна.

Тайлан онд авлага 217.1 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог илүү шилжүүлж авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 130,743.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нөхөн хангалтын зардлаар худалдан авсан, Боловсролын ерөнхий газраас 18,124.1 мянган төгрөг үнэ төлбөргүй орлого авч нийт үндсэн хөрөнгө тайланд онд 148,867.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 сарын 05-ны өдрийн 17/66 тоот тогтоолоор 56,706.5 мянган, 2 дугаар сарын 13-ны өдрийн 13/8 хөрөнгө актлах тогтоолоор 4,365,3 мянган төгрөгийн нийт 47,466.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Тайлант онд өмнөх оны өглөг төлөгдөж оны эцэст өр төлбөргүй байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 290,888.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 3,618,432.1 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 290,888.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,618,432.1 мянган төгрөг болсон байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,647,339.7 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 3,647,339.7 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 504,029.9 мянган төгрөгөөр буурч 3,143,309.8 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тайлант онд төсөвт 6 удаа тодотгол хийж тодотголоор 4,385,995.7мянган төгрөг болгож 1242,685.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 4,385,995.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 4,024,845.8 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 359,421.2 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна. Дансны үлдэгдлийг зардлаар нь үзвэл цалин , нийгмийн даатгал, үдийн хоолны зардлын үлдэгдэл 353,082.5 буюу 98,2 хувийг эзэлж байна

Орон нутгийн төсвөөс анх батлагдсан төсөв 667,959.1 мянган төгрөг 2023 оны 12 дугаар сарын 4-нд Баянхонгор сумын Засаг даргын А/334 дүгээр захирамжаар тодотгол хийж 31,500.0 мянган төгрөгөөр бууруулсан байна. Тодотгосон төсвөөр 636,459.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.3 хувь буюу 625,891.6 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 10,567.5 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 10,766,2 | 10,766,2 | 0.0 | 100.00% |
| 2 | 80312 Сургалт семинар | 5,383,1 | 5,379,4 | 3,7 | 99.93% |
| 3 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 16,856,4 | 10,936,2 | 5,920,2 | 64.88% |
| 4 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 317,809,3 | 270,534,2 | 47,275,1 | 85.12% |
| 5 | 81844 гүнзгийрүүлсэн сургалт | 34,370,0 | 34,365,8 | 4,2 | 99.99% |
| 6 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 112,567,2 | 112,567,2 | 0.0 | 100.00% |
| 7 | 81823 Боловсролын байгууллагын багш | 24,223,8 | 24,223,1 | 0,7 | 100.00% |
| 8 | 81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 28,980,1 | 19,438,1 | 9,542,0 | 67.07% |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 3,422,486,1 | 3,144,237,0 | 278,249,1 | 91.87% |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 407,853,5 | 389,444,2 | 18,409,2 | 95.49% |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээс | 4,700,0 | 2,200,0 | 2,500,0 | 46.81% |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 636,459,1 | 625,891,5 | 10,567,5 | 98.34% |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| ДҮН | 5,022,454,8 | 4,649,983,0 | 372,471,7 | 92.58% |

/

Эх сурвалж:2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 288,600.9 мянган төгрөгийн батлагдсан төсөвт 2 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын аргаар Гэгээн их ХХК, Софтвишин ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 282,216.2 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 106,297.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Сарангэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Цэрэндолгор нар зурж, хүнсний нярваар Б.Цолмон , аж ахуйн нярваар Л.Оюунцэцэг нар ажиллажээ.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 зугаар улирлын нийт зардлын 3,106,150.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,062.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 23,296.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант оны эцэст Үдийн хоол хөтөлбөрийн хүнсний материалын 6299.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гаргаж хүнсний материалыг нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.6 заалтаас бусад хуулийн хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,282,659.6 мянган төгрөгийн 83 гүйлгээ, зарлагын 934,992.0 мянган төгрөгийн 63 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, 238.0 мянган төгрөгийн төлбөрийн акт 16,186.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 3 | 238,0 | 3 | 238.0 | 100 |
| Зөвлөмж | 4 | 16186.9 | 4 | 16186,9 | 100.0 |
| Нийт дүн | 7 | 16,424.9 | 7 | 16,424.9 | 100.0 |

*Эх сурвалж: Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023.05.30-ны өдрийн 109 дугаар албан бичиг*

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.30-ны өдөр 109 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн акт, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,591.7 мянган төгрөгийн 3 зөрчил[1] илэрсэнд төлбөрийн акт, тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

**1. Зардалтай холбоотой**

1.Илрүүлэлт: Цахим хэрэглээний зардлаас захирал, нийгмийн ажилтан 3 хүнд нийт 240.0 мянган төгрөгийн дата өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралт 2.4 дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний зардлыг нийт үндсэн багш,бүлгийн болон хөгжим биеийн тамирын багш_ийн нийт тоогоор тооцно. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт буусаар олгосон датаны төлбөрийн 240.0 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Илрүүлэлт: Үдийн цайны хоолны материалын үнээс аж ахуйн материалын үнэнд 52.0 мянган төгрөг Софтвишн ХХК-д шилжүүлсэн.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан 52.0 мянган төгрөгийн төлбөрийг нягтлан бодогчоор төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой**

3.Илрүүлэлт:

Тайлант оны эцэст Үдийн хоол хөтөлбөрийн хүнсний материалын 6,299.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гаргаж хүнсний материалыг нөөцөлсөн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Засгийн газрын "Хоолны норматив тогтоох тухай" 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 4 дэх заалт “Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх”, гэсэн заалт, нь 2022 оны аудитаар үдийн цай хөтөлбөрийн дансны үлдэгдэл , хэмнэгдсэн төсвийн талаар Боловсролын газрын хэмжээнд дараагийн аудитаар анхаарах асуудлаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үдийн хоол хөтөлбөрийн материалын үлдэгдлийн үнэ 6,299.7 мянган төгрөгийг 2024 оны үдийн хоолны зардлаас төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим хэрэглээний зардлаас захирал, нийгмийн ажилтан 3 хүнд нийт 240.0 мянган төгрөгийн дата өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 240.0 | 1 | 240.0 | | | | |
| Үдийн хоолны материалын үнээс аж ахуйн материалын үнэнд 52.0 мянган төгрөг Софтвишн ХХК-д шилжүүлсэн. | 1 | 52.0 | 1 | 52.0 | | | | |
| Нийт дүн | 2 | 292.0 | 2 | 292.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант оны эцэст Үдийн цайны хоолны материалын 6299.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гаргаж хүнсний материал нөөцөлсөн. | 1 | 6299.7 | 1 | 6299.7 | | | | |
| Нийт дүн | 1 | 6299.7 | 1 | 6299.7 | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 60/14210513/БИА/2024 Номгон
177/ИА-СТА-ШП3.

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст Үдийн хоол хөтөлбөрийн хоолны материалын 6,299,700,0 төгрөгийн нөөц үлдэгдэлтэй байгаа нь 2022 оны аудитаар үдийн цай хөтөлбөрийн дансны үлдэгдэл, хэмнэгдсэн төсвийн талаар Боловсролын газрын хэмжээнд дараагийн аудитаар анхаарах асуудлаар зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Засгийн газрын "Хоолны норматив тогтоох тухай" 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 4 дэх заалт "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх", гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үдийн хоол хөтөлбөрийн материалын үлдэгдэл 6,299,700.00 /Зургаан сая

5050123

хоёр зуун ерэн есөн мянга долоон зуун / төгрөгийг 2024 оны төсвөөс төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын Номгон ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Сарангэрэл, нягтлан бодогч Т.Цэрэндолгор нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ



[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 22 өдөр Дугаар 01/142105731/5ТА-2024 /97/НА-СТА-П/243 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үдийн цайны хоолны материалын зардлаас аж ахуйн материалын үнэнд 52000 төгрөг Софтвишн ХХК-д шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны "Эдийн засгийн ангилал батлах тухай"190 дугаар тушаалыг мөрдөөгүй зардлыг ангилал, зориулалтын дагуу зарцуулаагүй, Үнэн ба зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 52,000 /тавин хоёр мянган / төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05

5050127

дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын Номгон ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Сарангэрэл, нягтлан бодогч Т.Цэрэндолгор нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 64/14210573/БПА/2024 /77/НА-СТА-ТШЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хэрэглээний зардлаас захирал, нийгмийн ажилтан 4 хүнд 240000 төгрөгийн дата эрх өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар 2.4 дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний зардлыг нийт үндсэн багш,/бүлгийн болон хөгжим ,биеийн тамирын багш/-ийн нийт тоогоор тооцно. гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 240,000 /Хоёр зуун дөчин мянган / төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

5050135

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баянхонгор сумын Номгон ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Сарангэрэл, нягтлан бодогч Т.Цэрэндолгор нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно